



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ
2019 ОН





ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ын Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Б.Мишээлт

ЧД-ын Статистикийн хэлтсийн гэрээт
ажилтан

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БАЙР 401 тоот.

Утас: 976-70113013

976-70110767

976-70130767

976-11-310767

Цахим хуудас: www.ubstat.mn,
www.chingeltei.gov.mn

Фэйсбүүк хаяг: [chingelteistatistic](https://www.facebook.com/chingelteistatistic)

И-мэйл: chingeltei@nso.mn



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГТ ХАМРАГДСАН АВТОМАШИНЫ ТОО

1.1 Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины төрөл


2019 онд техникийн хяналтын улсын үзлэгт Чингэлтэй дүүргийн 38496 машин хамрагдаж, өмнө жилийн мөн үеэс 2042 (5.04%) пунктээр буурчээ.

Чингэлтэй дүүрэгт бүртэгдсэн тээврийн хэрэгслийн мэдээллээс харахад суудлын автомашин 32749 буюу 85.1 хувь, ачааны автомашин 4769 буюу 12.4 хувь, автобус /нийтийн тээвэр/ 541 буюу 1.4 хувь, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл 437 буюу 1.1 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Автомашины үндсэн төрөл, дүнд эзлэх хувиар

Төрөл	2015		2016		2017		2018		2019	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Суудлын	28 372	77.3	28 228	77.7	30 655	78.0	31 328	77.3	32 749	85.1
Ачааны	6 560	17.9	6 638	18.3	7 153	18.2	7 652	18.9	4 769	12.4
Автобус	1 291	3.5	958	2.6	954	2.4	1 062	2.6	541	1.4
Тусгай зориулалтын	480	1.3	500	1.4	547	1.4	496	1.2	437	1.1
Бүгд	36 703	100	36 324	100	39 309	100	40 538	100	38 496	100


2019 онд тээврийн хэрэгслийн өсөлт бууралтыг төрлөөр нь задлан харвал, суудлын автомашин өмнө оны мөн үеэс 4.5 хувиар өсч, ачааны автомашин 37.7 хувь, автобус 49 хувь, харин тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл 11.9 хувиар тус тус буурчээ.



1.2 Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины өмчийн хэлбэр

Хувь хүмүүс, иргэдийн эзэмшилд бүртгэлтэй амины автомашины тоо 24906 байгаа нь үзлэгт хамрагдсан нийт автомашины 64.6 хувийг эзэлж байна. Энэ нь 2018 онтой харьцуулахад хувь хүмүүс, иргэдийн эзэмшилд бүртгэлтэй автомашин 17.3 хувиар буюу 8347 пунктээр буурсан байна.

Зураг 1. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан амины авто машины тоо




2019 оны техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн нийт автомашины 13590 нь (35.3%) аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшилд байгаагийн 967 (7.1%) төрийн болон орон нутгийн өмчийн, 56 нь (0.4%) дипломат болон олон улсын байгууллагын, 12567 нь (92.5%) компани, хоршоо, нөхөрлөлийн автомашин байна.

Хүснэгт 2. Автомашины тоо, өмчлөлийн хэлбэрээр, 2019 он

Үзүүлэлт	Бүгд	Суудлын	Ачааны	Автобус	Тусгай зориулалтын
Дүүргийн дүн	38 496	32 749	4 769	541	437
Төрийн болон орон нутгийн өмчийн	967	701	87	71	108
Дипломат, олон улсын байгууллагын	56	52	1	3	-
Төрийн бус байгууллагын	-	-	-	-	-
Компани, хоршоо, нөхөрлөлийн	12 567	10 556	1 588	182	241
Амины автомашин	24 906	21 440	3 093	285	88

1.3 Автомашины ашиглалтын хугацаа

2019 оны байдлаар Чингэлтэй дүүрэгт бүртгэлтэй тээврийн хэрэгслийг ашиглалтын /насжилт/ байдлаар авч үзвэл 0-3 жил ашиглагдаж буй автомашин 868 буюу 2 хувь, 4-9 жил болсон автомашин 9568 буюу 24.9 хувь, 10 ба түүнээс дээш жил ашиглагдаж буй автомашины тоо 28060 буюу 72.9 хувийг эзэлж байна.



2019 оны байдлаар өмнө жилийн мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэж гарсан хугацаанаас хойш 0-3 жил ашигласан автомашины тоо 465 буюу 115.4 хувь, 4-9 жил ашигласан автомашин 1146 буюу 13.6 хувиар тус, тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 10 ба түүнээс дээш ашигласан автомашин 3653 буюу 11.5 хувиар буурсан байна. Үүнээс суудлын автомашин 84 хувь, ачааны автомашин 13.9 хувь, автобус 1.3 хувь, тусгай зориулалтын автомашин 0.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 3. Автомашины тоо, ашиглалтын хугацаагаар

Үзүүлэлт	2018				2019			
	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш жил	Бүгд	0-3 жил	4-9 жил	10-аас дээш жил
Бүгд	40 538	403	8 422	31 713	38 496	868	9 568	28 060
Суудлын	31 328	281	6 957	24 090	32 749	658	8 514	23 577
Ачааны	7 652	67	1 085	6 500	4 769	122	756	3 891
Автобус	1 062	28	188	846	541	22	138	381
Тусгай зориулалтын	496	27	192	277	437	66	160	211

1.4 Үзлэгт хамрагдсан автомашины шатахууны төрөл, хөдөлгүүрийн багтаамж

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан Чингэлтэй дүүргийн 38496 автомашиныг хөдөлгүүрийн шатахууны төрлөөр ангилж үзэхэд 31994 (82.1%) нь бензин хөдөлгүүртэй автомашин ба үүнээс 80.6 хувь нь суудлын, 3.2 хувь ачааны, 0.4 хувь нь автобус, 5.9 хувь нь тусгай зориулалтын автомашин тус тус эзэлж байна.


2019 онд 2018 онтой харьцуулахад дүүргийн хэмжээнд бензин хөдөлгүүртэй автомашин 81 хувиар нэмэгдсэн бол дизель хөдөлгүүртэй автомашин 44.4 хувиар буурч 5726, хосолсон хөдөлгүүртэй автомашин 99.6 хувиар буурч 43, газ хөдөлгүүртэй автомашин 48.4 хувиар буурч 733 болсон үзүүлэлттэй байна.

Хүснэгт 4. Автомашины тоо, хөдөлгүүрийн төрлөөр

Үзүүлэлт	Бүгд		Үүнээс: автомашины үндсэн төрлөөр							
			Суудлын		Ачааны		Автобус		Тусгай зориулалтын	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Нийт дүн	40 538	38 496	31 328	32 749	7 652	4 769	1 062	541	496	437
Бензин	17 679	31 994	16 754	30 628	693	1 042	202	134	30	190
Дизель	10 294	5 726	2 087	1 389	6 895	3 691	847	400	465	246
Хосолсон	11 144	43	11 126	32	18	11	-	-	-	-
Газ	1 421	733	1 361	700	46	25	13	7	1	1

Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүүргийн 38496 автомашиныг хөдөлгүүрийнх нь багтаамжаар авч үзэхэд 16043 нь (41.7%), 1500 см³ хүртэл багтаамжтай автомашин, 14404 нь (37.4%) 1501-2500 см³ багтаамж бүхий хөдөлгүүртэй автомашин, 4034 нь (10.3%) 2501-3500 см³ багтаамж бүхий хөдөлгүүртэй автомашин, 1430 нь (3.7%) нь 3501-4500 см³ багтаамж бүхий хөдөлгүүртэй автомашин, 3221 нь (3.4%) 3501-4500 см³ багтаамж бүхий хөдөлгүүртэй автомашин байна.


Зураг 3. Автомашины тоо, хөдөлгүүрийн төрлөөр



Хүснэгт 5. Автомашины тоо, хөдөлгүүрийн багтаамжаар

Үзүүлэлт	Бүгд		Үүнээс: автомашины үндсэн төрлөөр							
			Суудлын		Ачааны		Автобус		Тусгай зориулалтын	
	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019	2018	2019
Нийт дүн	40 538	38 496	28 228	30 655	6 638	7 153	958	954	500	547
1500 см ³ хүртэл	15 921	16 043	15 495	15 666	425	352	-	-	1	25
1501-2500 см ³	15 385	14 404	11 129	11 856	3 612	2 252	603	265	41	31
2501-3500 см ³	4 536	4 034	2 528	2 897	1 516	940	303	174	48	23
3501-4500 см ³	1 475	1 430	1 242	1 183	162	186	38	25	33	36
4501 см ³ -ээс дээш	3 221	2 585	934	1 147	1 796	1 039	118	77	373	322


Зураг 4. Автомашины тоо, хөдөлгүүрийн багтаамжаар



1.5 Үзлэгт хамрагдсан автомашины тоо үйлдвэрлэсэн улсаар

Чингэлтэй дүүргийн хэмжээнд нийт 14 улсын 129 маркийн автомашин 2019 оны байдлаар үзлэгт хамрагдсан байна. Нийт автомашины 74.7 хувийг Япон улсад үйлдвэрлэсэн автомашин эзэлж байгаа бол 14.8 хувийг Солонгос, 1.6 хувийг Хятад, 1.3 хувийг Герман улсад үйлдвэрлэсэн автомашин тус тус эзэлж байна. Үлдсэн 7.6 хувийг Англи, Франц, Герман зэрэг улсад үйлдвэрлэсэн автомашин эзэлж байна.

Зураг 5. Үзлэгт хамрагдсан автомашины тоо, үйлдвэрлэсэн улсаар



Чингэлтэй дүүргийн автомашин 2019

Үзлэгт хамрагдсан автомашин, үйлдвэрлэгдсэн улсаар



Автомашини тоо, шатахууны төрлөөр



Автомашини хувь, хөдөлгүүрийн багтаамжаар



1500 см³ хүртэл



1501-2500 см³



2501-3500 см³



3501-4500 см³



4501 см³ дээш

Автомашин 2019

